



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/01/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.24 № 96
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЗОРИГТБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Жаргалант сумын 2022 оны төсвийн орлогыг сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 387,353.1 мянган төгрөгөөр тодотгон баталж, гүйцэтгэлээр 529,269.6 мянган төгрөг бүрдүүлсэн байна. Төсвийн 6 нэр төрлийн орлого 38,048.5 мянган төгрөгөөр тасарч, 9 нэр төрлийн орлого 179,965.0 мянган төгрөгөөр давж, нийт дүнгээр төсвийн орлого давж биелсэн байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Жаргалант сумын уурын зуухыг Засаг даргын тамгын газарт хариуцуулан ажиллуулж байгаад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Жаргалант ус, дулаан түгээх станц” хувьцаат компанийг байгуулсантай холбоотойгоор 2022 оны 09 сараас энэхүү компанид үйл ажиллагааг нь шилжүүлж, санхүүгийн тайланг нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэсэн байна.

Жаргалант сумын уурын зуухны нүүрсний үнийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байна.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын төсвийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжиж босоо тогтолцоотой болсон тул сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төвийн балансын үзүүлэлтүүд холбогдох төвлөрүүлэн захирагчдад шилжиж, эдгээр байгууллагууд орон нутгаас олгож буй санхүүжилтийн хүрээнд орлого, зардал бүртгэж нэгтгүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,279,481.1	1,574,436.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	386,025.4	516,346.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	436,012.4	104,985.7
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	427,443.3	863,224.7
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	30,000.0	89,880.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		9,164,529.4	9,987,171.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	9,164,529.4	9,987,171.7
39200	Биет хөрөнгө		9,082,508.6	9,960,797.2
39300	Биет бус хөрөнгө	13	82,020.8	26,374.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		10,444,010.4	11,561,608.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		321,892.4	335,133.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	321,892.4	335,133.3
41300	Өглөг	17а, 17б	321,892.4	335,133.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		10,122,118.1	11,226,474.9
51	Засгийн газрын хувь оролцоо		10,122,118.1	11,226,474.9
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,784,413.4	715,438.1
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		0.0	715,438.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		0.0	4,172,689.5
51200	Хуримтлагдсан үр дүн		4,590,319.0	5,139,017.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		3,747,385.6	1,199,330.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		10,444,010.4	11,561,608.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		5,855,971.8	9,240,425.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		146,374.9	497,952.3
110	Орлогын албан татвар		87,037.5	322,585.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		87,037.5	322,585.2
113	Хөрөнгийн албан татвар		16,990.2	104,956.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж		42,347.3	70,410.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	890,186.7	3,589,836.3
120	Нийтлэг татварын бус орлого		890,186.7	3,589,836.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,819,410.2	5,152,636.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	5,975,867.6	4,744,034.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,975,867.6	4,744,034.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,816,234.1	4,702,424.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,175,218.7	789,327.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		284,320.2	98,647.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		317,319.9	535,815.3
2104	Хангамж, бараа материалын зардал		407,508.7	1,451,367.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		959,211.8	440,458.4
2107	Томилолт, зочны зардал		71,896.8	2,088.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		325,488.2	402,087.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,073,118.7	982,633.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		159,633.6	41,610.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-119,895.8	4,496,391.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		10,857.9	7,562,456.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-130,753.7	-3,066,065.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөн хийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,252,871.80	0	10,252,871.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,710.90	0	7,710.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,260,582.80	0	10,260,582.80
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-7,710.90	0	-7,710.90
9	Тайлант үеийн үр дүн	-130,753.70	0	-130,753.70
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,122,118.10	0	10,122,118.10
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,122,118.10	0	10,122,118.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,267.00	0	-2,267.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,119,851.10	0	10,119,851.10
17	Өмчид гарсан өөрчилөлт	4,172,689.50	0	4,172,689.50
19	Тайлант үеийн үр дүн	-3,066,065.70	0	-3,066,065.70
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,226,474.90	0	11,226,474.90

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тод руулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		5,136,735.90	5,991,576.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО		146,374.90	497,952.30
110	Орлогын албан татвар		87,037.50	322,585.20
1100	Хувь хүний орлогын албан татвар		87,037.50	322,585.20
113	Хөрөнгийн албан татвар		16,990.20	104,956.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		42,347.30	70,410.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		4,994.70	5,034.10
1181	Газрын төлбөр		9,661.40	44,406.20
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		27,691.20	20,970.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		163,058.80	340,168.40
120	Нийтлэг татварын бус орлого		163,058.80	340,168.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,827,302.20	5,153,455.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,026,745.40	2,770,112.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,026,745.40	2,770,112.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,863,120.70	2,729,803.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,164,901.60	859,592.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		282,571.20	117,583.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		349,549.80	650,164.30
2104	Хангамж, бараа материалын зардал		269,058.90	239,794.10
2105	Нормативт зардал		128,494.00	18,363.60

2106	Эд хогшил, урсгал засварын зардал		204,408.50	470,889.70
2107	Томилолт, зочны зардал		71,896.80	2,088.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		310,722.20	303,954.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		81,517.60	67,373.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		163,624.80	40,309.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		1,109,990.40	3,221,463.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		1,007,482.20	3,091,043.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,007,482.20	3,091,043.20
2200	Дотоод эх үүсвэрээр		1,007,482.20	3,091,043.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		1,007,482.20	3,091,043.20
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-58,100.00	-100
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		58,100.00	100
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		44,408.20	130,320.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		341,617.20	386,025.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		386,025.40	516,346.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,402,093.1	5,060,779.7
УРСГАЛ ЗАРДАЛ	2,163,279.3	2,053,031.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,126,903.3	2,016,659.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,943.6	679,217.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,822.6	93,805.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	412,266.4	382,333.8
Хангамж, бараа материалын зардал	169,897.1	168,851.3
Нормативт зардал	10,000.0	7,484.0
Эд хогшил, урсгал засварын зардал	372,178.9	372,178.6
Томилолт, зочны зардал	3,750.0	2,088.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	254,480.6	250,136.2
Бараа үйлчилгээний бусад зардал	60,564.1	60,564.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,376.0	36,372.7
Бусад урсгал шилжүүлэг	36,376.0	36,372.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,081,431.0	3,007,648.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	157,382.8	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,402,093.1	5,021,886.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,511,059.8	2,511,059.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,448,359.1	2,432,590.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	442,674.2	78,235.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		276,962.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		237,872.2
БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.0	0.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	0.1	0.1
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.1	0.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	586,550.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	582,122.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	559,549.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,070.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,278.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,481.5
2104	Хангамж, бараа материалын зардал	47,846.6
2105	Нормативт зардал	10,879.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	177,678.3
2107	Томилолт, зочны зардал	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,318.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,996.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,572.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,626.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,946.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,428.0
2200	Дотоод эх үүсвэрээр	4,428.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	576,271.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	576,271.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-10,279.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,279.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 19,787.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 3 зөвлөмж өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд /E-report/ системээр нийт 10 байгууллага нэгтгэгджээ. Боловсрол, соёл, эрүүл мэндийн 4 байгууллага нь босоо тогтолцоотой болсон тул балансын үзүүлэлтүүд шилжиж, орон нутгаас авсан санхүүжилтийн хүрээнд орлого, зардлаа тайлагнаж байна.

Дүгнэлт гаргасан байгууллагуудаас Жаргалант сумын ЗДТГ-ын болон Засаг даргын нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, ИТХ-ын тайлан хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн түвшинд

Илрүүлэлт:

Жаргалант сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ирүүлэхдээ баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүн, түүний танилцуулга бэлтгэж ирүүлээгүй байна. Энэ нь Төвийн тухай хуулийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.4-д "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн биелэлтийн танилцуулга, хэрэгжилтийн хамт бэлтгэж ирүүлж хэвших.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жаргалант сумын тайлант оны төсвийн нийт орлогоор сумын ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, ОНХС-ийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.6-д "хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх", 60.2-д "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ", 60.2.4-д "татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Тухайн жилийн төсвийн нийт орлогоор ОНХС-ийн хөрөнгийг нэмэгдүүлэн төлөвлөхийг таслан зогсоож, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хуулийн дагуу бүрдүүлэх эх үүсвэрийн хүрээнд төлөвлөж хэрэгжүүлэх.

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумын төсвийн орлого нийт дүнгээр давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр бүрдүүлэх боломжтой малын хөлийн албан татварыг 17,980.9 мянган төгрөгөөр, төсвийн байгууллагын өөрийн орлогыг 1,806.1 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн орлогыг нэр төрөл тус бүрээр бүрэн бүрдүүлэхэд чиглэсэн бололцоотой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлж, чиг үүргийн албан хаагчдын хариуцлагыг сайжруулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жар. Засаг дарга	3	19,787.1					3	19,787.1				
Жар.ЗДТГ	5	4,197.4	2	2,233.6	1	0.0	2	1,963.8				
Жар.ИТХ	5	35,386.9	1	258.0	3	35,128.9	1	0.0				
Жар.ОНХСан	2	96,429.6					2	96,429.6				
Жар.Хоршоо хөгжүүлэх сан	2	24,253.9	1	15,683.5			1	8,570.4				
Жаргалант ус, дулаан түгээх станц ОНӨХК	2	0.0					2	0.0				
Дүн	19	180,054.9	4	18,175.1	4	35,128.9	11	126,750.9				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	4	2	2		1	1		
2	ОНӨААН	1		1					
3	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	6	3	3		2	1		